

## СУРГАЛТЫН АЖЛЫН ТАЙЛАН

**Захиалагч:** Монголын бэлчээр ашиглагчдын нэгдсэн холбоо ТББ  
**Хугацаа:** 2020.10.17 – 2020.11.01  
**Гүйцэтгэгч :** МХЗХҮХолбоо

---

### **Зорилго.**

Ногоон Алт-Малын Эрүүл мэнд төслийн үйл ажиллагаа явуулж буй сумдын малчдын ХЗХ дэмжих зорилгоор МХЗХҮХолбоо сургалт, мониторинг- зөвлөмжийг Говь-Алтай, Ховд, Баян-Өлгий, Увс, Завхан, Архангай ХЗХоршоодод бүсчлэн зохион байгуулах.

### **Сургалт, мониторинг хийсэн багш нар**

- Увс- Баян-Өлгий, Ховд аймаг: Х.Даваадолгор, У.Болормаа, СЗХ-ны мэргэжилтэн С.Номинчулуун – 2020/10/17-2020/10/20
- Завхан аймаг, Ц.Оюунцэцэг, Н.Цэрэнлхам 2020/10/24-2020/10/27

### **Гүйцэтгэсэн ажил**

- ХЗХ-дын удирдлагыг чадавхижуулах 2 өдрийн танхимын сургалтыг зохион байгуулж, ХЗХоршоодын ТЗ, ХЗ болон ЗХ-ны гишүүд, ГЗ, нягтлан бодогч нарыг хамарсан 88 хүн оролцсон / **Хавсралт № 1/**
- Нийт 10 ХЗХ-ын үйл ажиллагаанд үнэлгээ хийж зөвлөгөө өгсөн. /Үнэлгээний тайлан тусдаа тайлангаар хүргүүлнэ./

**Нийт зарцуулсан төсөв 11 760 000 сая төгрөг /Дэлгэрэнгүй хавсралт№2/**

### **Гарсан үр дүн**

- ХЗХоршооны сонгуульт болон гүйцэтгэх удирдлагуудын хоршооны тухай болон зөвлөл тус бүр өөрсдийн хийх ажлын цар хүрээ, үүргийн талаарх мэдлэгтэй болсон.
- ХЗХоршоодын удирдлагуудын өмнө шийдвэрлэгдэж чадаагүй болон ойлгомжгүй асуудлуудын талаар нэгдсэн нэг ойлголттой болсон.
- СЗХорооноос тавигдсэн шаардлагын дагуу СЗХ, МХЗХҮХолбооны хамтарсан батламж гардуулсан.
- Хоршоод харилцан туршлага хуваалцаж, өсч хөгжих хүсэл эрмэлзлэлтэй болж хоршоодын удирдлагуудын хандлага өөрчлөгдсөн.
- Өөрийн хоршооны алдаа дутагдлыг олж харж, засч сайжруулах боломжийг олж авсан.

# 1. УВС, БАЯН-ӨЛГИЙ, ХОВД АЙМГИЙН НОГООН АЛТ ТӨСЛИЙН ХЗХ-ДЫН УДИРДЛАГЫГ ЧАДАВХИЖУУЛАХ СУРГАЛТЫН ТАЙЛАН

**Сургагч багш нар:** Б.Номинчулуун (СЗХ-ны ХШЗГ-ын МУТА-ны хянан шалгагч),

У.Болормаа (“Хас баяжих” ХЗХ-ны гүйцэтгэх захирал), Х.Даваадолгор (“Монум” ХЗХ-ны зээлийн эдийн засагч).

**Сургалт хийсэн хугацаа:** 2020 оны 10-р сарын 17-20-ны өдрүүдэд Баян-Өлгий аймгийн Өлгий хот, АБАХ-ын байр, “Малчин төв”-ийн сургалтын танхимд явагдсан.

**Сургалтанд хамрагдсан хоршоо, ажилтнууд:** Баян-Өлгий аймгийн “Аухат хоры”, “Малчны хөгжил”, “Хундымура”, “Бугаты дамысы”, “Булган дамысы”, Увс аймгийн “Ногоон төгрөг финанс”, “Давст өрнөн дэлгэрэх”, Ховд аймгийн “Мөнхийн буян дэлгэрэх”, “Хаан гал тамга” ХЗХ-дын ТЗ, ХЗ, ЗХ-ний гишүүд, гүйцэтгэх захирал, нягтлан бодогч нийт 45 хүн. *(Ирцийн бүртгэлийг хавсаргав)*

## Сургалтын арга, хэлбэр:

- ✓ Сургалтын эхэнд сургагч багш нар 2 байгууллагын хооронд байгуулсан гэрээний хүрээнд хийж гүйцэтгэх ажил, одоо хийх гэж байгаа сургалтынхаа зорилгыг танилцуулав.
- ✓ Мөн оролцогчдоос судалгаа авахад өмнө нь сургалтанд сууж байсан оролцогч цөөхөн (4-5-хан) хүн байсан тул анхан шатны сургалтын модулиар сургалтыг явуулахаар тогтов.
- Оролцогчдод өөрийгөө болон хоршоогоо танилцуулах хугацаа олгож, сургалтын туршид баримтлах дүрмээ баталсан нь цаг ашиглалтыг сайжруулж, сургалтанд оролцох идэвхийг нэмэгдүүлсэн.
- Сургалтыг дараах агуулгын хүрээнд, онол дадлага хослуулсан хэлбэрээр явуулав. (Хөтөлбөр болон сургалтын модулийг тус тус хавсаргав). Үүнд:

### I өдөр:

- ХЗХ-ны бусад санхүүгийн байгууллагаас ялгагдах онцлог,
- ХЗХ-ны түүхэн хөгжил (Олон улсад болон Монголд)
- ХЗХ-ны ОУ-ын суурь зарчмууд. (4 бүлэг, 37 зарчим)
- Банкнаас бусад санхүүгийн зах зээлийн тойм.  
Зах зээлд гарсан өөрчлөлт, нөлөөлөл  
СЗХ-ны үйл ажиллагаа, зохицуулалтын байгууллагууд
- МУТСТэмцэх үйл ажиллагаа.  
МУТСТ гэмт хэргийн тухай  
Зохицуулалтын орчин  
ФАТФ-ын үнэлгээний талаар  
Монгол улс ба саарал жагсаалт  
Урьдчилан сэргийлэх арга хэмжээ.

### II өдөр:

- ЗХШҮ-ийг хэрхэн тооцоолох аргачлал, өгөгдөлд суурилсан удирдлагын шийдвэр гаргалт. (оролцогчдыг 3 бүлэгт хуваан - кейс ажиллуулав.)
  - Монголбанкны зээлийн мэдээллийн сангийн тухай, ЗМА-тай гэрээ байгуулах, хамтран ажиллах, ЗМС-нд мэдээлэл нийлүүлэх, мэдээлэл авсны ач холбогдол зэрэг ойлголтыг өгсөн.
  - ТЗ, ХЗ-ийн үйл ажиллагаа, эрх үүрэг, хариуцлага.
  - ГЗ болон нягтлан бодогч, зээлийн ажилтны үйл ажиллагаа, тайлагналын систем.
  - Тулгамдаад буй асуудал гэсэн сэдвийн хүрээнд сургалтыг явуулсан болно.
- Багш нарын зүгээс, сургалтын агуулгын хүрээнд оролцогчдын гүйцэтгэх гэж буй ажлын талаарх ойлголтыг тодруулан асууж, дутуу ойлгосон зүйл дээр нь нэмж тайлбарлан тодорхой болгож өгсөн.

- Түүнчлэн оролцогсод бие биеэсээ харилцан туршлага судалж өөрсдийн үйл ажиллагаанд шинэ соргог зүйлсийг нэвтрүүлэх боломж олгосон нь сургалтын ач холбогдлыг нэмэгдүүлсэн.

**Сургалтын талаарх дүгнэлт:** 2 өдрийн танхмын дадлага сургалтанд оролцсон 12 ХЗХ-ны 45 оролцогсдыг сонгуульт ажлаар нь ангилбал дараах байдалтай байв.

№	ХЗХ-ны нэр	ТЗөвлөл	ХЗөвлөл	ЗХороо	Гүйцэтгэх захирал	Нягтлан бодогч	Нийт
1	Хундымура	1		2	1		4
2	Бугаты дамысы			1		1	2
3	Давст өрнөн дэлгэрэх	2			1		3
4	Аухат хоры	1	1		1	1	4
5	Булган дамысы		1			1	2
6	Малчны хөгжил	2				1	3
7	Дэлүүн буян	1	1		1	1	4
8	Мөнхийн буян өгөөж	1	2	1		1	5
9	Хаан гал тамга	1	1	1	1	1	5
10	Үенч арвижин дэлгэрэх	2	1	1			4
11	Ногоон төгрөг финанс		1	2		1	4
12	Тэнгэрийн оргил гоо	2	1	1	1		5
<b>НИЙТ</b>		<b>13</b>	<b>9</b>	<b>9</b>	<b>6</b>	<b>8</b>	<b>45</b>

#### **Сургалтын эхний өдрийн үдээс өмнө:**

- ХЗХ-ны талаарх сүүрь ойлголт, ОУ-ын зарчмын талаар сургалт хийж, тухайн ойлголтын талаарх оролцогчдын мэдлэгийг тодорхойлох, шинэ мэдлэг, мэдээлэл өгөх, ойлголтын зөрүүг арилгахаар харилцан ярилцаж, хамтран ажилласан. Оролцогчид хоршооллын зарчмын талаар тодорхой хэмжээний мэдлэг, мэдээлэлтэй байсан ба харин хадгаламж зээлийн хоршоо нь санхүүгийн байгууллага болохын хувьд баримтлах зарчим, явуулах үйл ажиллагааны талаар нэмэлт мэдлэг олгосон болно.

#### **Сургалтын эхний өдрийн үдээс хойш:**

- СЗХ-ны ХШЗГ-ын МУТА-ны хянан шалгагч, сургагч багш Б.Номинчулуун санхүүгийн зах зээлийн өнөөгийн байдал, зохицуулалтын дүрэм журмын талаар мэдээлэл өгч, ФАТФ-ын саарал жагсаалт, МУТСТ үйл ажиллагааны талаар сургалт хийсэн. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх талаар оролцогчдын дийлэнхи хэсэг ойлголтгүй байсан ба нэр томъёо нь шинэ, энэ нь өнөөдөр бидэнд тулгараагүй асуудал гэсэн байдлаар хандаж төдийлөн анхаарал хандуулахгүй байдал ажиглагдаж байв.

#### **Сургалтын 2 дахь өдрийн үдээс өмнө:**

- ЗХШҮ-ийг тооцох аргачлал, ялангуяа чанаргүй зээл, түүнд байгуулах ЗЭС-ийн хүрэлцээ, түүнтэй холбоотой хийгдэх НББ-ийн талаар дэлгэрэнгүй сургалт хийлээ. Өгсөн мэдээллийг хэрэглэж сургахын тулд дадлага ажил хийлгэхээр 3 баг болгож ЗХШҮ-ийн тайлангийн 3 өөр кейс өгч ажиллуулсан. Хоршоод хоорондоо хамтран ажиллах, туршлага солилцох боломжийг олгохын тулд 12 хадгаламж зээлийн хоршооноос оролцогчдыг багт хуваахдаа өөр өөр хоршоодыг нийлүүлэн хуваариллаа. Багууд кейсэд өгөгдсөн нөхцлийг тодорхойлж, тухайн ХЗХ-ны үйл ажиллагааг үнэлэн, тулгарсан асуудлыг шийдвэрлэхийн тулд авах арга хэмжээг хэлэлцэн шийдвэрлэсэн. Гаргасан дүгнэлт, шийдвэрээ баг тус бүрээс 1 төлөөлөл гарч танилцуулахад бусад багууд өөрсдийн санаа бодлоо мөн илэрхийлж оролцсон. Энэ явцад багш нар хяналт тавьж, өгөгдсөн нөхцлийг гүйцэд тодорхойлох, шийдвэрлэх асуудал, арга замыг бүрэн гаргах, орхигдуулахгүй байхад анхаарч, шинэ, оновчтой санааг дэмжиж ажилласан ба СЗХ-ны багшаас ХЗХ-дын ЗХШҮ-ийн тайланг илгээхдээ гаргадаг алдаа, анхаарах зүйлс дээр дэлгэрэнгүй зөвлөмж өгч ажилласан нь оролцогчдоос талархал хүлээсэн сургалт болсон. Сургалтын завсарлагааны үеэр зарим оролцогчид өөрсдийн тайланг СЗХ-ны багшид хянуулан алдаагаа олж, тусгайлсан зөвлөмжийг авч ажилласан.

- Мөн Монгол банкны зээлийн мэдээллийн сангийн талаар холбогдох мэдээлэл, зөвлөмжийг өгсөн.

#### **Үдээс хойш:**

Сургалт 2 тусдаа танхимд явагдсан.

- Сургагч багш У.Болормаа ТЗ, ХЗ-ийн 22 гишүүнд зориулан ТЗ, ХЗ-ийн гишүүнээр ямар шаардлага хангасан гишүүнийг хэрхэн сонгох, ямар үүрэг, хариуцлага хүлээх, хэрхэн ажиллах талаар хуулийн заалт, үлгэрчилсэн дүрэмд хэрхэн заасныг таниулж, бодит жишээгээр тайлбарласан. Хоршооны сонгуульт гишүүд, орон тооны ажилтан нарын ялгааг сайн ойлгоогүй, хоршооны үйл ажиллагааг ганц хоёрхон хүнд найддаг байдал ажиглагдаж байна. Сургалтын төгсгөлд хадгаламж зээлийн хоршооны түүх, онцлог, баримтлах зарчим, засаглалын асуудлаар тест бөглүүлсэн.

- Сургагч багш Б.Номинчулуун, Х.Даваадолгор нар ГЗ, ЗХорооны гишүүн, нягтлан бодогч нарт зориулсан сургалтыг явуулсан ба уг сургалтанд 23 хүн оролцсон. ХЗХ-ны өдөр тутмын үйл ажиллагааг явуулдаг гүйцэтгэх захирал, нягтлан бодогч, зээлийн хорооны гишүүдийн хувьд тэдний эрх, үүрэг, хариуцлага, ХЗХ-ны үйл ажиллагааны болон санхүүгийн төлөвлөлтийг хэрхэн төлөвлөх, ТЗ, ХЗ-д үйл ажиллагаагаа тайлагнах, хэрхэн хамтран ажиллах талаар дэлгэрэнгүй ойлголтыг өгсөн. Түүнчлэн “ХЗХ-ны активыг ангилах, активын эрсдлийн сан байгуулж, зарцуулах журам”-ын дагуу зээлийн багцын ангилалын хэрхэн зөв хийх, холбогдох ЗЭС-г байгуулах, хуримтлагдсан зээлийн хүүгийн авлагыг буцаах, балансын гадуур бүртгэх, чанаргүй зээл төлөгдсөн тохиолдолд холбогдох гүйлгээг хэрхэн хийх талаар дэлгэрэнгүй тайлбарлаж өгсөн.

Сургалтын төгсгөлд оролцогчид өөрсдийн мэдэхгүй байгаа зүйлс, тулгамдаад буй асуудал, хуулийн хэрэгжилтийн талаар багш нараас асуулт асууж заавар, зөвлөмжийг авч ажилласан.

#### **Сургалтын гурав болон дөрөв дэх өдөр.**

Хамтын ажиллагааны гэрээнд заасны дагуу сургалтанд оролцогч ХЗХ-дын үйл ажиллагаанд сургагч багш нарын зүгээс үнэлгээ хийсэн. Эхний 2 ХЗХ-дод үнэлгээ хийх үед СЗХ-ны ХШЗГ-ын МУТА-ны хянан шалгагч Б.Номинчулуун өөрийн чиг үүргийн дагуу хоршоодын МУТСТ чиглэсэн дотоод журам, СЗХ-оос ирүүлсэн үүрэг даалгавар, түүний хэрэгжилт, ЗХШҮ-ийн тайлангийн алдаа зэрэгт дүгнэлт, зөвлөмж өгч ажилласан нь ихээхэн ач холбогдолтой байлаа. Үнэлгээ хийхэд шаардлагатай материалыг авчрах үүргийг хоршоод гүйцэд биелүүлээгүйгээс зарим асуудлыг баримтад тулгуурлах бус харилцан ярилцах замаар үнэлсэн нь үнэлгээний дүнг бууруулах нэг хүчин зүйл болсон. Цаашид үнэлгээг газар дээр нь иж бүрнээр хийлгэдэг байх шаардлагатайг анхаарна уу. (Үнэлгээний хэсгийн тайланг тусад нь хүргүүлэх болно).

#### **Сургагч багш нараас өгсөн үүрэг даалгавар, зөвлөмжүүд:**

- ✓ ГА болон сонгуульт хороод өөрсдийн үйл ажиллагааг идэвхижүүлж тогтмолжуулах.
- ✓ Хоршоодын удирдлага нь санхүүгийн салбарын талаар илүү мэргэшиж, тайлан балансаа унших, санхүүгийн шинжилгээ хийх чадвараа сайжруулах шаардлагатай.
- ✓ Санхүүгийн тайланг цаг хугацаанд нь холбогдох байгууллагуудад цахим болон цаасаар хүргүүлж хэвших.
- ✓ МУТСТ хууль болон МУТСанхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журмыг хэрэгжүүлэх талаар анхаарч ажиллах. Үүний түлд МУТСТ тухай хууль, түүний хэрэгжилтийг хэрхэн хангах, мэдээлэх үүрэгтэй этгээд, эцсийн өмчлөгч, ХЗХ-ны МУТСТ чиглэсэн эрсдлийн удирдлагын болон дотоод хяналтын хөтөлбөр, хөтөлбөрийн хэрэгжилт хариуцсан ажилтны эрх үүрэг зэргийн талаар илүү дэлгэрэнгүй сургалтыг явуулах шаардлагатай.
- ✓ ТЗ, ХЗ, ЗХ-ний үйл ажиллагааг тогтмолжуулах, тэднийг дараагийн шатны сургалтанд хамруулан мэргэшүүлэх, туршлага судлуулах.
- ✓ Гүйцэтгэх захирал, нягтлан бодогч нарыг санхүүгийн анхан шатны баримт бичиг, санхүүгийн тайланг НББ-ын журам, зааврын дагуу бүртгэх, тайлагнах сургалтанд хамруулах.
- ✓ Ганц хүнд буюу зөвхөн ГЗ-д ачаалал өгөхгүйгээр, ТЗ, ХЗ, ЗХ-ны гишүүд бүгд ажлаа хуваан авч, манлайлан оролцох.
- ✓ ХЗХ-ны одоо мөрдөж буй бодлого, журам, зааврыг хянаж үзэх, шаардлагатай бол шинэчлэн боловсруулж, хэлэлцүүлэн батлуулах, үйл ажиллагаандаа мөрдөх.
- ✓ Монголбанкны зээлийн мэдээллийн албатай холбогдож гэрээ байгуулах, мэдээлэл солилцох үйл ажиллагааг идэвхжүүлэх, мэдээлэл солилцох боломжгүй бол түүнийг нотлох.
- ✓ Сургалтанд хамрагдсан сонгуультан болон гүйцэтгэх албаны ажиллагсад хоршоон дээрээ ирээд сурсан зүйлээ бусадтайгаа хуваалцаж мэдээлдэг, сургалтын тайлан бичдэг байх.
- ✓ ХЗХ-д МУТСТ чиглэсэн эрсдлийн удирдлагын болон дотоод хяналтын хөтөлбөрийг хууль, журамд нийцүүлэн дахин шинэчлэн боловсруулж, батлах, СЗХ-нд хүргүүлэх.

- ✓ Албан бичгийн хөтлөлт, гишүүдийн болон сонгуульт гишүүдийн хувийн хэрэг зэргийг стандартын дагуу хөтөлж хэвших.
- ✓ Үнэлгээний дүнд үндэслэн сургагч багш нарын зүгээс өгсөн үүрэг даалгаврыг хугацаанд нь, чанартай хийж гүйцэтгэн үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллах.
- ✓ МХЗХҮХолбоотой байнгын холбоотой ажиллаж, шаардлагатай тусламж, дэмжлэгийг авдаг байх.

## 2. ЗАВХАН, ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН НОГООН АЛТ ТӨСЛИЙН

### ХЗХ-ДЫН УДИРДЛАГЫГ ЧАДАВХИЖУУЛАХ СУРГАЛТЫН ТАЙЛАН

**Хамрагдсан ХЗХоршоод:** 4 аймгийн 13 сумын 13 ХЗХоршоод хамрагдав.

**Говь-Алтай аймгийн** Баян-Уул сумын “Вангийн Ивээл” ХЗХ, Дэлгэр сумын “Хөгжин дэлгэрэх” ХЗХ, Эрдэнэ сумын “Дэвжин ундрах эрдэнэ” ХЗХ,

- **Завхан аймгийн** Яруу сумын “Яруу саяаар дэлгэрэх” ХЗХ, Тэс сумын “Дөрвөн уулын хишиг” ХЗХ, Шилүүстэй сумын “Лүн мянганы оргил”, Цэцэн уул сумын “Зоос өртөө” ХЗХ, Тэлмэн сумын “Тэлмэн тэгш хэм” ХЗХ
- **Архангай аймгийн** Тариат сумын “Ургах наран уран мандал”, Чулуут сумын “Малчны хуримтлал”
- **Баянхонгор аймгийн** Жинст сумын “Жинст бодь мөнгөн сүрэг” ХЗХ

**Хугацаа:** 2020 оны 10-р сарын 25-нээс 2020 оны 10-р сарын 27-ны өдөр.

**Сургагч багш:** Ц.Оюунцэцэг - “Кредит Юнион Монгол” ХЗХ-ны гүйцэтгэх захирал, Б.Цэрэнрхам - “Алтан давалгаа” ХЗХ-ны дарга нар сургалт үнэлгээг явуулав.

#### **НЭГ: СУРГАЛТЫН ЯВЦ:**

Сургалтын эхэнд оролцогчдоо таниж мэдэх, хоршооны үйл ажиллагааны талаар ямар түвшиний ойлголттой оролцогчид байгааг, сургалтанд аль сэдвийг түлхүү анхаарч заах хэрэгтэйг тодорхойлох судалгаа авав.

- ✓ Сургалтд бүх оролцогчдод өөрийгөө болон хоршоогоо танилцуулах хугацаа олгож, сургалтын туршид баримтлах дүрмээ баталсан нь цаг үр дүнтэй ашиглах нөхцлийг бүрдүүлсэн.
- ✓ Сургагч багш нар томилолтын хугацаанд хийж гүйцэтгэх ажил, сургалтын хөтөлбөр, зорилгыг танилцуулав.
- ✓ Сургалтыг хөтөлбөрийн хүрээнд онол, дадлага хослуулсан хэлбэрээр явуулав. Багш нарын зүгээс, сургалтаар заасан онолын агуулгын хүрээнд оролцогчдын хоршооны үйл ажиллагаатай нь хийцэж буй эсэхийг тодруулж, буруу ташаа, дутуу ойлгосон зүйл дээр нь зөвлөмж тайлбар өгч ажиллаа.
- ✓ Мөн оролцогчид бие биеэсээ харилцан туршлага судалж өөрсдийн үйл ажиллагаанд шинэ соргог зүйлсийг нэвтрүүлэх боломжийг олгосон нь сургалтын ач холбогдлыг нэмэгдүүлсэн.

**Сургалтын талаарх дүгнэлт:** 2 өдрийн танхимын сургалтанд тусгай зөвшөөрөл бүхий 11 ХЗХ-ны 41, дөнгөж үүсгэн байгуулагдаад буй түсгй зөвшөөрөл аваагүй 2 хоршооноос тус тус нэг хүн нийт 43 оролцогчдыг сонгуульт ажлаар нь ангилбал дараах байдалтай байв.

Зээлийн хорооны гишүүн 1 хүн оролцсон нь Зээлийн хороонд гүйцэтгэх захирал, нягтлан бодогчыг ТЗ-өөс томилон оруулсантай холбоотой гэж үзэж байна. 8 - н сонгуульт бус гишүүн оролцсоныг ирээдүйд сонгуульт албан тушаалд бэлтгэгдэж буй гишүүд гэж ойлгосон. “Вангийн Ивээл” ХЗХ-ны хувьд ТЗ-ийн гишүүд, гүйцэтгэх захирал, нягтлан бодогч нар нь өмнө нь шат дараалсан сургалтанд хамрагдсан тул үинээр сонгогдсон сургалтанд хамрагдаагүй ХЗ-ийн гишүүд нь оролцов. Тэлмэн тэгш хэм, Ургах наран мандал хоршоодоос нэгч сонгууль ажилтанууд оролцсонгүй.

№	ХЗХ-ны нэр	ТЗ	ХЗ	ЗХ	Гүйцэтгэх захирал	Нягтлан бодогч	Гишүүн	Нийт
1	Вангийн Ивээл		3					3
2	Хөгжин дэлгэрэх	2	1		1	1		5
3	Дэвжин ундрах эрдэнэ		1			1	2	4
4	Яруу саяаар дэлгэрэх	2	2					4
5	Дөрвөн уулын хишиг	2				1		3
6	Лүн мянганы оргил		1			1	2	4
7	Зоос өртөө	1	1	1		1	2	6

8	Тэлмэн тэгш хэм					1		1
9	Ургах наран уран мандал				1		2	3
10	Малчны хуримтлал	2			1	1		4
11	Жинст бодь мөнгөн сүрэг	2	1		1	1		5
12	Тусгалт туна	1						1
13	Алтан цул	1						1
<b>НИЙТ</b>		<b>13</b>	<b>9</b>	<b>1</b>	<b>4</b>	<b>8</b>	<b>8</b>	<b>44</b>

Сургалтаар – СЗХ, МХЗХҮХ-ны хамтарсан батламжтай сургалтанд оролцогчид зориулж СЗХ-ноос бэлтгэсэн сургалтын модулиар санхүүгийн зах зээлийн өнөөгийн байдал, ХЗХ-дын зохицуулалтын дүрэм, журмын талаар мэдээлэл өгч, ФАТФ-ын саарал жагсаалт, МУТСТ үйл ажиллагааны талаарх сургалтыг хийсэн. Сургалтанд оролцогчид Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх талаар бараг ойлголтгүй байсан ба нэр томъёо нь шинэ, тэдэнд энэ асуудал ойрын хугацаанд тулгарахгүй гэсэн байдлаар хандагатай байсныг сургалтаар бага ч гэсэн өөрчилсөн гэж бодож байна.

Сургалтанд оролцогчид нь хоршооны гол удирдлагуудын төлөөлөл байсан ба ихэнх нь санхүүгийн асуудлыг нягтлан бодогч л мэднэ өөрсдөд нь төдийлөн чухал биш гэсэн ойлголттой байсан. Сургалтаар ХЗХ бол санхүүгийн байгууллага тийм учраас Сонгуульт болон гүйцэтгэх удирдлага бүгд санхүүгийн тайлан уншиж чаддаг, ЗХШҮ гэж юу болох удирдага эндээс ямар мэдээллийг харж ойлгож, дүгнэлт хийж, шийдвэр гаргалтандаа ашиглах ёстой талаар, түүнийг тооцох аргачлал, ялангуяа чанаргүй зээл, түүнд байгуулах ЗЭС-ийн хүрэлцээ, түүнтэй холбоотой хийгдэх НББ-ийн тооцоололын талаар дэлгэрэнгүй сургалт хийж, ЗХШҮ-ийн тайлангийн 3 өөр дасгал өгч ажиллуулсан.

ХЗХ-дын ЗХШҮ-ийн тайланг илгээхдээ гаргадаг алдаа, анхаарах зүйлс дээр дэлгэрэнгүй зөвлөмж өгч ажилласан.

Мөн Монгол банкны зээлийн мэдээллийн сангийн талаар холбогдох мэдээлэл, зөвлөмжийг өгсөн. Монголбанкны зээлийн мэдээллийн албатай холбогдож гэрээ байгуулах, мэдээлэл солилцох үйл ажиллагааг идэвхжүүлэх, мэдээлэл солилцох боломжгүй бол тэр талаарх шалтгааныг тодорхойлсон албан тоотыг аргүүлж байх ёстойг зөвлөв.

Сургалтын төгсгөлд оролцогчид өөрсдийн мэдэхгүй байгаа зүйлс, тулгамдаад буй асуудал, хуулийн хэрэгжилтийн талаар багш нараас асуулт асууж заавар, зөвлөмжийг авч ажилласан. Нийт сургалтанд оролцогчид СЗХ, МХЗХҮХолбооны хамтарсан батламж гардуулсан.

#### **Сургагч багш нараас өгсөн зөвлөмжүүд:**

- ✓ ГА болон сонгуульт хороод өөрсдийн үйл ажиллагааг идэвхижүүлж, Сонгуульт хороод хууль дүрэмд заасны дагуу хяналт шалгалтаа хийж хуралдаанаа тогтмолжуулах, тэднийг дараагийн шатны сургалтанд хамруулан мэргэшүүлэх, туршлага судлуулах.
- ✓ Хоршоодын удирдлага нь санхүүгийн салбарын талаар илүү мэргэшиж, тайлан балансаа унших, санхүүгийн шинжилгээ хийх чадвараа сайжруулах шаардлагатай.
- ✓ Санхүүгийн тайланг цаг хугацаанд нь холбогдох байгууллагуудад цахим болон цаасаар хүргүүлж хэвших.
- ✓ Гүйцэтгэх захирал, нягтлан бодогч нарыг санхүүгийн анхан шатны баримт бичиг, санхүүгийн тайланг НББ-ын журам, зааврын дагуу бүртгэх, тайлагнах сургалтанд хамруулах.
- ✓ Ганц хүнд буюу зөвхөн ГЗ-д эсвэл нягтланд хоршооны бүх ажлыг үүрүүлж, ачаалал өгөх нь нэг хүнээс хэт хамааралтай болж алсдаа хоршоонд эрсдэл үүсэх нөхцлийг бүрдүүлдэг тул ТЗ, ХЗ, ЗХ-ны гишүүд бүгд ажлаа хуваан авч, манлайлан оролцох.
- ✓ ХЗХ-ны одоо мөрдөж буй бодлого, журам, зааврыг хянаж үзэх, шаардлагатай бол шинэчлэн боловсруулж, хэлэлцүүлэн батлуулах, үйл ажиллагаандаа мөрдөх.
- ✓ МУТСТ хууль болон МУТСанхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журмыг хэрэгжүүлэх талаар анхаарч ажиллах. МУТСТ чиглэсэн эрсдлийн удирдлагын болон дотоод хяналтын хөтөлбөрийн талаарх сургалтуудад эхний ээлжинд гүйцэтгэх албаны ажилчдыг хамруулах
- ✓ Сургалтанд оролцогчид хоршоон дээрээ очоод сурсан мэдсэнээ бусадтайгаа хуваалцаж мэдээлж тайлагнадаг байх, тэдгээрээс үйл ажиллагаандаа нэвтрүүлэх талаар зөвлөв.
- ✓ Албан бичгийн хөтлөлт, гишүүдийн болон сонгуульт гишүүдийн хувийн хэрэг зэргийг стандартын дагуу хөтөлж хэвших.

- ✓ Үнэлгээний дүнд үндэслэн сургагч багш нарын зүгээс өгсөн үүрэг даалгаврыг хугацаанд нь, чанартай хийж гүйцэтгэн үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллах.
- ✓ МХЗХҮХолбоотой байнгын холбоотой ажиллаж, шаардлагатай тусламж, дэмжлэгийг авдаг байх.

Тайланг нэгтгэсэн:

МХЗХҮХолбооны гүйцэтгэх захирал

Б.Амаржаргал